



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“АВТО ТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨҮГ-ЫН
2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН
АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2019/134/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор Б.Сэржмядаг

Утас: 260512 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Мэдээлэл аудит” ХХК

Утас: 70159511 Цахим хаяг: medeelelaudit@gmail.com

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/134/СТА-ТӨҮГ

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	8
2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Шилэн дансны мэдээлэл	9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3. Менежментийн захидал	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Батлагдсан зорилтот түвшний биелэлт	13
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	13

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04 37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВ" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
П.ДЭЛГЭРНАРАН ТАНАА

2018.03.15 № 06/438
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлтийн болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус газрын захирал П.Дэлгэрнаран Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн удирдлагын дээд болон дотоод хяналт, татварын тооцоолол, тайлагнал зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 10 дугаар сарын 08-наас 2019 оны 3 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 11-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, "Мэдээлэл-Аудит" ХХК-ийн чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа анхан шатны чанарын хяналт хэрэгжүүлж, багийн ахлагч Ахлах аудитор Д.Товуудорж, Аудитор Д.Туяа, Аудитор Э.Отгонзаяа, шинжээч С.Наранцэцэг нар аудитыг хариуцаж хэрэгжүүлэв.

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгыг "Мэдээлэл-Аудит" ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 1/412 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ нь Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, тээвэрлэлтийг мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх Авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох, Автотээврийн хэрэгсэлд тавигдах техникийн хяналт, Тээврийн хэрэгслийн бүртгэлийг хэрэгжүүлэх, хөгжүүлэх, нийгмийн хэрэгцээг хангасан аюулгүй, ая тухтай үйлчилгээний нөхцөлийг бий болгох гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Улсын бүртгэлийн гэрчилгээнд "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх
- Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх
- Улс хооронд, хот хооронд, орон нутгийн зорчигч болон ачаа тээвэр, шуудан, нийтийн тээвэр, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээ болон дамжин өнгөрөх тээвэрлэлтийн үйлчилгээг улсын хэмжээнд зохицуулах, зохион байгуулах
- Улс хооронд, хот хооронд, орон нутгийн нийтийн зорчигч, ачаа болон дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хяналт, мэдээллээр хангах

- Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох
- Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг аймаг, орон нутагт зохион байгуулах
- Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, техникийн хяналт, засвар үйлчилгээний хэмжилтийн тоног төхөөрөмжүүдийг шалгаж, тохируулга, баталгаажуулалт хийх

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ нь үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын удирдлага нь дараах хууль болон СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Нийгмийн даатгалын багц хууль
- Татварын багц хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Автотээврийн тухай хууль /1999.06.04/
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль /2015.07.08/
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль /2001.02.01/
- Захиргааны хариуцлагын тухай хууль /1992.11.27/
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль /1995.04.17/
- Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль /2003.05.15/
- Өрсөлдөөний тухай хууль /2010.06.10/

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт шинэчлэлт гараагүй.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын захрлын 2017 оны А/169 тоот тушаалаар батлагдан мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "UNICUS" програм хангамж ашигладаг байна.

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь төрийн тодорхой чиг үүргийг дангаараа хэрэгжүүлдэг, орлого бүрдүүлэлт монополь шинж чанартай, харин зардал нь удирдлагын шийдвэрээс шууд шалтгаалдаг тул нийт зарлагыг суурь болгон авч, эрсдэлтэй асуудлыг тодорхойлох нь зүйтэй гэж үзлээ.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 19,777.9 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 197.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд тус байгууллагын мэдээ, мэдээлэлтэй танилцсаны үндсэн дээр материаллагын хувийг сонгосоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 9 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд

тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг нягтлан бодох бүртгэлд буруу бүртгэснээс хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс 454.7 сая төгрөөр дутуу илэрхийлэгдсэн.
- Замын-Үүд салбар нь дулааны шугамыг тавилга эд хогшил дансанд бүртгэгдсэн байснаас эд хогшил дансанд 11.3 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдэл тооцогдсон байна.
- "АТУТ" ТӨҮГ нь 2018 онд төрийн өмчийг түрээслэж олсон орлогоос 2.9 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	2.8	
2	Албан шаардлага өгсөн	1	20.6	
	Дүн	3	23.4	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Удирдлагын дээд болон дотоод хяналт

Зам, тээврийн хөгжлийн яамны удирдлага болон мэргэжилтнүүдийн гадаад томилолтын зардалд 20.6 сая төгрөг зарцуулсан.

Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Монгол улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 8 дугаартай Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай тогтоолын 2.2-т "төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх, ТӨБЗГ-ын 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдрийн 380 тоот Шалгалтын мөрөөр арга хэмжээ авах тухай тогтоолын 2.6-д "...Зам тээврийн яамны албан тушаалтнуудын гадаад албан томилолтын зардлыг байгууллагаас хариуцдаг явдлыг зогсоох" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн, тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын хувьд дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

2018 оны батлагдсан зорилтот түвшингийн төлөвлөгөөг сар, улирлын хуваарийн дагуу төлөвлөгөөний санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төлөвлөгөөг зардлын төрөл, зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Зорилтот түвшний тодотгосон төлөвлөгөөгөөр 21,309.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөснөөс 25,592.2 сая төгрөгийн орлоготой ажиллаж 120 хувиар биелүүлсэн.

Нийт зардлыг 17,822.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 101 хувиар буюу 18,009.2 сая төгрөгийг зарцуулж, татварын өмнөх ашгийг төлөвлөгөөнөөс 217 хувиар давуулан биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 7072 мэдээлэл оруулахаас 4441 мэдээлэл оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Удирдлагын дээд болон дотоод хяналт

3.1.1 Илрүүлэлт:

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 7072 мэдээлэл оруулахаас 4441 мэдээлэл оруулсан нь "эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй.

3.1.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдэл зөрчигдөх
- Ил тод байдал алдагдах

3.1.3 Өгсөн зөвлөмж

- Шилэн дансны мэдээллийг иж бүрэн мэдээлж, зөрчлийг давтахгүй байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Манайх олон салбартай тул шилэн дансны хэрэгжилт тухайн салбарын удирдлага, санхүүгийн ажилтаны хариуцлагаас шалтгаалан харилцан адилгүй байдаг. Бид дотоод хяналтаа сайжруулан цаашид анхаарч ажиллана.

3.2 Татварын тооцоолол, тайлагнал

3.2.1 Илрүүлэлт:

Ажиллагсадын цалингаас суутгах Хувь хүний орлогын албан татварыг 2.8 сая төгрөгөөр дутуу суутгасан байна. Энэ нь "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээг баримтлаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

- Санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал", "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүд зөрчигдөх
- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж

- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг мөрдөж, татварын хөнгөлөлтийн тооцоог үнэн зөв хийж, татварыг нөхөн тайлагнаж төлөх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт програмаар бодогддоггоос энэ алдаа гарсан байна. Бид цаашид хянаж анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2018	12/31/2018
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		
1.1.2	Дансны авлага	1,743,325,354	2,254,065,055
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	3,735,153	
1.1.4	Бусад авлага	23,987,176	20,092,098
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	96,215,165	92,151,110
1.1.6	Бараа материал		
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,486,664,028	1,816,458,155
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	2,349,767,005	2,783,884,835
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	18,628,000	22,231,000
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	5,722,321,881	6,988,882,253
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө		
1.2.2	Биет бус хөрөнгө	16,572,260,277	24,167,755,571
1.2.3	Биологийн хөрөнгө	292,712,358	6,482,378,742
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	5,748,715	
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,870,721,349	30,650,134,313
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	22,593,043,230	37,639,016,566
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг	198,349,788	311,288,169
2.1.1.3	Татварын өр	150,123	
2.1.1.4	НДШ-ийн өглөг	49,078,721	24,222,248
2.1.1.5	Богино хугацаат зээл	943,200	79,182
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	324,651,420	
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	106,139,986	113,807,192
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	679,313,238	449,396,791
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	6,606,464,648	6,595,492,627
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		41,075,999
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	6,606,464,648	6,636,568,626
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,285,777,887	7,085,965,417
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	241,840,000	241,840,000
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	133,416,650	2,335,778,667
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	12,399,299,420	19,668,192,378
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,532,709,273	8,307,240,104
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	15,307,265,343	30,553,051,149
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	22,593,043,230	37,639,016,566

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	17,668,317,291	20,020,830,178
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	14,163,199,702	15,368,610,921
4	Түрээсийн орлого	3,505,117,589	4,652,219,257
5	Хүүгийн орлого	103,227,680	136,893,257
6	Ногдол ашгийн орлого	267,254,116	274,601,628
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал	4,720,271,602	5,159,845,944
10	Ерөнхий ба удирдлагын зардал	279,387,933	14,020,000
11	Санхүүгийн зардал	1,290,953,653	1,281,025,407
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		53,184,831
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-234,660,662	-410,759,992
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-657,718,391
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	-291,038,605	-223,853,753
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6,499,830,133	7,582,997,711
19	Орлогын татварын зардал	1,264,338,258	1,768,700,255
20	Татварын дараах ашиг (алдагдал)		
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	5,235,491,875	5,814,297,456
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	53,952,247,273	26,683,969,624
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	23,836,192,842	25,332,819,394
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар	30,790,554	
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого		
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	30,085,263,877	1,351,150,230
1.2.1	Ажиллагчдад төлсөн	50,346,776,859	20,189,151,287
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	9,271,466,595	9,874,098,762
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,627,247,755	1,487,681,542
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	598,715,738	623,264,625
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	780,081,520	1,093,517,010
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	538,030,441	402,699,687
1.2.7	Хүүгийн төлбөрт төлсөн	460,318,390	62,294,305
1.2.8	Татварын байгууллагад төлсөн	3,098,550,151	3,704,711,664
1.2.9	Даатгалын төлбөрт төлсөн	57,968,723	93,479,713
1.2.9	Бусад мөнгөн зарлага	33,914,397,546	2,847,403,979
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,605,470,413	6,494,818,337
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	253,517,212	274,601,628
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	1,655,000	
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	251,862,212	274,601,628
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,634,524,681	6,258,680,265
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,064,979,042	5,036,186,665
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	115,533,880	278,646,130
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,381,478,709	-5,984,078,637
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	471,240	

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4		471,240	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	1,454,011,759	943,847,470
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	1,454,011,759	422,414,500
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			521,432,970
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	224,934,184	510,739,700
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,518,391,171	1,743,325,354
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,743,325,354	2,254,065,055

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	241,840,000			134,585,950		11,959,488,314	-1,745,617,778	10,590,296,487
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-596,441,024	-596,441,024
3	Залруулсан үлдэгдэл								0
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)							5,235,491,875	5,235,491,875
5	Бусад дэлгэрэнгүй орлого								0
6	Өмчид гарсан өөрчлөлт						439,811,106		439,811,106
7	Зарласан ногдол ашиг							-360,723,800	-360,723,800
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-1,169,300				-1,169,300
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	241,840,000			133,416,650		12,399,299,420	2,532,709,273	15,307,265,343
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-39,766,626	-39,766,626
11	Залруулсан үлдэгдэл								0
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							5,814,297,456	5,814,297,456
13	Бусад дэлгэрэнгүй орлого								0
14	Өмчид гарсан өөрчлөлт						7,268,892,958		7,268,892,958
15	Зарласан ногдол ашиг								0
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				2,202,362,017				2,202,362,017
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	241,840,000	0	0	2,335,778,667	0	19,668,192,378	8,307,240,104	30,553,051,149

4.5 Батлагдсан зорилтот түвшний биелэлт

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(сая төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2017 он		2018 он		Тайлант оны төлөвлөгөө, гүйцэтгэл	
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувиар	Хэтрэлт, хэмнэлт
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт							
Үүнээс	Үүнээс: Техникийн хяналт оношлогоо	тоо хэмжээ	10,921.9	11,633.8	11,525.0	12,604.9	109%	1,079.9
	Зорчигч тээвэр.	зорчигч болон ачаа эргэлт	6,347.2	9,374.3	8,617.0	10,242.6	119%	1,625.7
	Бүртгэл, Бусад	сая /төг	1,609.6	1,750.9	1,167.4	2,744.7	235%	1,577.3
2	Нийт орлого	сая /төг	18,878.6	22,759.1	21,309.3	25,592.2	120%	4,282.8
3	Нийт зардал	сая /төг	16,874.6	16,259.2	17,822.0	18,009.2	101%	187.1
4	Татварын өмнөх ашиг	сая /төг	2,004.0	6,499.8	3,487.3	7,583.0	217%	4,095.7
5	Цэвэр ашиг/алдагдал	сая /төг	1,803.6	5,235.5	2,615.5	5,814.3	222%	3,198.8
6	Орлогын татварт	сая /төг	200.4	1,264.3	871.8	1,768.7	203%	896.9
7	Төсвийн төлбөрт	сая /төг	2,215.0	4,473.0	5,123.6	4,490.4	88%	(633.2)
8	Нийт авлага	сая /төг	99.5	100.0	78.5	112.2	143%	33.7
9	Нийт өглөг	сая /төг	7,715.6	6,855.0	7,095.2	7,086.0	100%	(9.2)
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	сая /төг	0.89	0.71	0.84	0.70	84%	(0.1)
11	Ногдол ашгийн өглөг	сая /төг	291.5	523.4	523.1	523.1	100%	-
12	Хөрөнгө оруулалт	сая /төг	5,091.3	4,824.5	6,200.3	5,447.7	88%	752.7

"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2019.03.15			САГ-2019/134/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Зам, тээврийн хөгжлийн яамны удирдлага болон мэргэжилтнүүдийн гадаад томилолтын зардалд 20.6 сая төгрөг зарцуулсан.	20.6	Албан шаардлага	Захирал, Санхүү эдийн засгийн хэлстийн дарга	П.Дэлгэрнаран Я.Оюунсүрэн
2	Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу 7072 мэдээлэл оруулахаас 4441 мэдээлэл оруулсан байна.	-	Зөвлөмж өгсөн	Захирал, Хяналт шинжилгээ, дотоод аудитын албаны дарга	П.Дэлгэрнаран Б.Баатарцол
	Ажиллагсадын цалингаас суутгах ХХОАТ-ыг 2.8 сая төгрөгөөр илүү хөнгөлж, татварыг дутуу суутгасан байна.	2.8	Зөвлөмж өгсөн	Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга	Я.Оюунсүрэн
	Дүн	23.4			

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]